

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД, БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2017 оны 11 дүгээр
сарынны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 6 дугаар хэсэг, Ойн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Байгаль орчны хууль тогтоомжийн зөрчлийг илрүүлсэн буюу зөрчлийн талаар бодит мэдээлэл өгсөн иргэнд урамшуулал олгох журам"-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү тушаалын хавсралтаар баталсан журмыг хэрэгжүүлэх, биелэлтэнд нь хяналт тавих арга хэмжээ авч ажиллахыг Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар /Г.Нямдаваа/, Ойн бодлого зохицуулалтын газар /М.Тунгалаг/, Санхүүгийн хэлтэс /Б.Нансалмаа/, Сангийн яамны Төсвийн бодлого зохицуулалтын газар /...../, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Байгаль орчин, аялал жуулчлал, геологи, уул уурхайн хяналтын газар /Д.Батбаяр/, бүх шатны Засаг дарга нарт даалгасугай.

САНГИЙН САЙД

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД

С.ХҮРЭЛБААТАР

Н.ЦЭРЭНБАТ

Сангийн сайд,
Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2017 оны ...дугаар тушаалын хавсралт

Байгаль орчны хууль тогтоомжийн зөрчлийг илрүүлсэн буюу зөрчлийн талаар бодит мэдээлэл өгсөн иргэнд урамшуулал олгох журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Байгаль орчны хууль тогтоомжийг зөрчсөн үйлдлийг илрүүлэн арилгах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн идэвхи санаачлагыг дэмжих зорилгоор байгаль орчны хууль тогтоомжийн зөрчлийг илрүүлсэн буюу зөрчлийн талаар үнэн зөв мэдээлэл ирүүлсэн, зөрчлийг илрүүлэхэд бодит туслалцаа үзүүлсэн иргэнд урамшуулал олгох харилцааг зохицуулна.

1.2. Байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээллийг ирүүлсэн дараах субъект хамаарна. Үүнд:

1.2.1. Иргэн;

1.2.2. Байгаль хамгаалагч;

1.2.3. Байгаль орчны хяналтын улсын байцаагч;

1.2.4. Байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа нөхөрлөл;

1.2.5. төрийн бус байгууллага;

1.2.6. Цагдаа, хил хамгаалах байгууллагын ажилтан

Хоёр. Мэдээллийг хүлээн авах

2.1. Байгаль орчны зөрчлийн талаарх мэдээллийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, сумын байгаль орчны хяналтын улсын байцаагчийн нэр дээр бичгээр ирүүлнэ. Ирүүлсэн мэдээллийг байгууллагын бичиг хэрэгт бүртгүүлж, удирдлагад танилцуулж, шийдвэрлэнэ.

2.2. Мэдээллийг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, аймаг, нийслэлийн Байгаль орчны газар, аймаг, нийслэл, сум, дүүрэг, хот, тосгоны Засаг дарга, Захирагчид ирүүлж болох бөгөөд эдгээр, байгууллага, албан тушаалтан нь уг мэдээллийг нягтлан шалгуулж, холбогдох хариуцлага тооцуулахаар энэ журмын 2 дугаар зүйлийн 2.1-т заасан нэр дурдсан байгууллага, албан тушаалтанд шилжүүлнэ.

2.3. Мэдээллийг хүлээн авсан байгууллага нь мэдээлэлд дурдсан зүйлийг шалгуулахаар аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын газарт, аймаг, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар нь сумын байгаль орчны хяналтын улсын байцаагчид шилжүүлж болно. Мэдээлэл нь гэмт хэргийн шинжтэй байвал Цагдаагийн байгууллагад шилжүүлж, шалгуулна.

2.4.Гадаад улсын иргэн, харъяалалгүй хүмүүс энэхүү журмын дагуу мэдээлэл өгч болно.

2.5.Мэдээллийг хүлээн авахдаа бусдын эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хохироохоор гүтгэсэн, бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн болон иргэний нэр хүндийг гутаан доромжилсон нь шалгалтын явцад тогтоогдвол Эрүүгийн хуулийн 11.2 дугаар зүйлийн дагуу хариуцлага хүлээлгэхээр хууль, хяналтын байгууллагад материалыг шилжүүлэх талаар мэдээлэгчид урьдчилан танилцуулж, гарын үсэг зуруулна.

2.6.Иргэний мэдээлэл болон түүнд нэр дурдсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага мэдээлэгчийн нэр хаяг, нууцыг чандлан нууцлана.

Гурав.Мэдээлэлд тавих шаардлага, мэдээлэгчийн үүрэг хариуцлага

3.1.Мэдээлэлд зөрчил гаргасан газар, аймаг, сум, дүүрэг, баг, хороо, хот, тосгоны нэр, зөрчлийг илрүүлэгч, мэдээлэгч, гэрчийн овог, нэр, гэрийн хаяг, ажлын газар, эрхэлдэг ажил, харилцах утасны дугаар, тэдэнтэй холбоо барих хаяг, арга зам, тээврийн хэрэгсэл ашигласан бол түүний марк, дугаар, өнгө, содон тэмдэг, зөрчлийн хэлбэр, зөрчил гарсан газар түүнээс учирсан хохирол, хууль бус үйлдэлдээ ашигласан техник тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, мод, ургамал, ашигт малтмал, ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн зэрэг биет зүйл, байгалийн нөөц баялгийг бэлтгэх, олборлоход хэрэглэх, ашиглахыг хуулиар хориглосон тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, химийн хорт болон аюултай бодис бусад эд зүйлийг тээвэрлэсэн, хадгалсан, худалдаалж байгаа орон байр, агуулах, граж, контейнерийн байршил зэргийг аль болох тодорхой, ойлгомжтой дурдсан байна.

3.2.Байгаль орчны зөрчлийн талаарх мэдээлэл нь бодитой бус, нотлох баримтгүй тодорхой иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэр хүндийг гутаах зорилготой, хувийн өш хонзонгийн чанартай, зөрчлийг нотлох баримтгүй, ул мөр нь арилсан, зөрчил үйлдэгч нь тодорхойгүй, худал ташаа мэдээллийг хүлээн авахгүй.

3.3.Мэдээлэлд дурдсан зөрчил нь тодорхойгүй, нотлох баримтгүй, гүтгэлгийн чанартай буюу буруу ташаа болох нь тогтоогдсон бол түүнээс үүдэн гарах гэм буруу, хохирол, гарсан зардлыг тухайн мэдээлэгч хариуцахыг тайлбарлан, сануулж гарын үсэг зуруулж баталгаажуулна.

Дөрөв. Мэдээллийг хянан шийдвэрлэх

4.1.Мэдээллийг шалгаж шийдвэрлэхдээ Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай багц хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Төрийн жинхэнэ албан хаагчийн ёс зүйн дүрэм зэрэг холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу явуулна.

4.2.Мэдээлэлд дурдсан зөрчлийг шалгаж шийдвэрлэх хугацаа нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу 30 хоног байх ба энэ хугацаанд багтааж шалгаж,

мэргэжлийн хяналтын байгууллага, байгаль орчны хяналтын улсын байцаагчийн хэмжээнд шийдвэрлэсэн бол уг зөрчлийг шалгаж барагдуулсан өдрөөс хойш ажлын 10 хоногт багтаан мэдээлэгчид хариу өгнө. Тухайн зөрчлийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хууль, хяналтын байгууллагаар шалгуулах шаардлагатай бол энэ талаар мэдээлэгчид урьдчилан мэдэгдэнэ.

Тав. Мэдээлэгчийг урамшуулах

5.1..Аливаа зөрчлийг илрүүлсэн буюу ноцтой зөрчлийн талаар цаг үеэ олсон бодитой үнэн зөв, тодорхой мэдээлэл ирүүлсэн иргэнд мөнгөн урамшуулал олгоно.

5.2.Мэдээлэлд дурдсан зөрчил нь хөдлөшгүй баримтаар нотлогдож эцэслэн шийдвэрлэгдсэн тохиолдолд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн орлого нь зохих дансанд төлөгдсөний дараа уг торгууль, нөхөн төлбөрийн орлогын дүнгийн 15 хувиар тооцож мөнгөн урамшууллыг мэдээлэгчид олгоно.

5.3.Байгаль орчны ноцтой зөрчлийг илрүүлсэн, эсвэл зөрчлийн талаар мэдээлэл өгсөн, зөрчлийг илрүүлэхэд бодит туслалцаа үзүүлсэн иргэн, байгаль орчны чиглэлийн үйл ажиллагаа явуулж байгаа нөхөрлөл, төрийн бус байгууллага нь мэдээллийнхээ хариуг авсаны дараа мөнгөн урамшуулал авах тухай хүсэлтээ нутаг дэвсгэрийн харъяалсан тухайн шатны Засаг даргад хандаж өргөдөл бичнэ.

5.4.Өргөдлийг хүлээн авсан байгууллагын удирдлага нь уг мэдээллийн мөрөөр шалгалт хийсэн байгаль орчны хяналтын улсын байцаагчаас албан ёсны тодорхойлолт гаргуулсны үндсэн дээр торгууль, нөхөн төлбөрийн орлогын 15 хувьтай тэнцэх мөнгөн урамшуулал олгох талаар шийдвэр гаргана.

5.5.Мэдээллийн дагуу хяналт шалгалт хийх явцад тухайн мэдээлэлд дурдагдаагүй бусад зөрчил илэрсэн тохиолдолд уг зөрчлийг үйлдсэн этгээдэд ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн орлогоос мэдээлэгчид урамшуулал олгохгүй.

5.6.Мэдээлэгчид мөнгөн урамшуулал олгох тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг үндэслэн тухайн байгууллагын санхүүгийн асуудал хариуцсан нэгж нь урамшууллыг эзэнд нь саадгүй олгох ажлыг хариуцан гүйцэтгэнэ.

Зургаа. Мэдээлэгчийг урамшуулах санхүүгийн эх үүсвэр

6.1.Мэдээлэгчийг урамшуулахад шаардагдах торгууль, нөхөн төлбөрийн орлогын 15 хувийг зөрчил гаргагчид ногдуулж, орон нутгийн төсвийн орлого /төрийн сан/-ын дансанд оруулсан торгууль, нөхөн төлбөрийн орлогоос гаргана.

6.2.Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээний харъяа байгууллага нөхөн төлбөрийн орлогыг Байгаль орчин, уур амьсгалын санд төвлөрүүлнэ.

6.3. Гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд ашиглаж хураалгасан зэвсэг, тээврийн хэрэгсэл, унаа хөсөг, техник, тоног төхөөрөмжийг зохих шийдвэрийн дагуу

борлуулсан тохиолдолд борлуулсны орлогын 70 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал хүсэх тухай хүсэлтээ тухайн гэмт хэрэг, зөрчлийг илрүүлсэн нөхөрлөл, төрийн бус байгууллага, цагдаа, хил хамгаалах байгууллагын ажилтан нь байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд гаргана.

6.3. Гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд ашиглаж хураалгасан зэвсэг, тээврийн хэрэгсэл, унаа хөсөг, техник, тоног төхөөрөмжийг борлуулсны орлогын 70 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг тухайн гэмт хэрэг, зөрчлийг илрүүлсэн нөхөрлөл, төрийн бус байгууллага, цагдаа, хил хамгаалах байгууллагын ажилтанд байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно. /тодруулах/

6.4. Мэргэжлийн хяналтын байгууллагын улсын байцаагч орон нутагт хяналт шалгалтын ажлаар явж байгаад зөрчил гаргагчдаас хураасан эд зүйлийг тухайн аймаг, сумын холбогдох байгууллага, албан тушаалтан, улсын байцаагч, байгаль хамгаалагчид албан ёсоор хүлээлгэн өгсөн тохиолдолд уг эд зүйлийг зохих журмын дагуу борлуулсны дараа урамшуулал олгох шийдвэрийг уг эд зүйлийг хураасан улсын байцаагчийн хүсэлтийг үндэслэн олгоно.

6.5. Байгаль орчны улсын хяналтын байцаагч, байгаль хамгаалагч хэн нэгэн мэдээлэгчийн оролцоогүйгээр өөрөө зөрчлийг илрүүлж, эд зүйлсийг хураан улсын орлого болгосон тохиолдолд урамшуулал авах эрх үүснэ.

Долоо.Бусад зүйл

7.1.Мэдээллийг хүлээн авснаас хойш хууль тогтоомжид заасан хугацаанд шалгаж шийдвэрлээгүй, хариу өгөөгүй, мэдээлэл шалгах ажилд хариуцлагагүй хандсан, мэдээллийн нууцыг задруулсан, мэдээлэгчид олгох урамшууллыг олгоогүй, дутуу, буруу олгосон албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага ногдуулна.

7.2.Энэ журамд заасан урамшууллыг Амьтны аймгийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1-д заасан урамшуулалтай давхардуулан олгохгүй бөгөөд уг хуульд дурдсан урамшуулалыг олгохдоо энэхүү журмыг баримтлана.

Холбогдох саналаа: sainbayar@mne.gov.mn Утас: 51-264826
jagdag@mne.gov.mn Утас: 51-261726

Дээрх хаягаар ирүүлнэ үү баярлалаа